СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2024/46/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он


Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын
Дарга,тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Даваанням
Утас: 88095436 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн
Захирал: Ч.Энхчимэг
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Аудитор: Б.Бүрэнжаргал
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/139

танай ______ -ны № ______ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-УУЛ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Н.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

"Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 40.1 хувиар өссөн байна.

### Аудитын гол асуудал

Тус байгууллагын даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/01 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" 107 дугаар тогтоолд заасан цалингийн хэмжээг нэмэгдүүлж 2023 оны эхний хагас жилд 15,919.1 мянган төгрөгийн цалинг албан хаагчдад илүү олгосон байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын дарга нь 2023 онд хэрэгжүүлж ажиллах гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө Сумын Засаг даргаар 4 зорилтын хүрээнд 107 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж 90.3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

6724040293

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **263,482,060.48** | **239,001,918.30** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 92,800,442.17 | 40,191,057.85 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 92,800,442.17 | 40,191,057.85 |
| **3121** | **Төгрөг** | 92,800,442.17 | 40,191,057.85 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 92,800,442.17 | 40,191,057.85 |
| **33** | **АВЛАГА** | - | 40,416,549.70 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 40,416,549.70 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 170,681,618.31 | 158,394,310.75 |
| **351** | **Түүхий эд материал** | 88,515,600.38 | 56,729,154.91 |
| 35130 | Эм боох материал | 88,515,600.38 | 56,729,154.91 |
| **354** | **Хангамжийн материал** | 82,166,017.93 | 101,665,155.84 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 9,133,050.00 | 14,097,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 55,498,470.63 | 59,738,045.94 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 170,000.00 | 3,115,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4,928,028.00 | 911,400.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,562,750.00 | 12,652,750.00 |
| 35460 | Хүнсний материал | 10,873,719.30 | 11,150,259.90 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **803,885,527.80** | **660,854,998.41** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 803,885,527.80 | 660,854,998.41 |
| **392** | **Биет хөрөнгө** | 790,137,527.76 | 647,194,998.33 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 330,915,290.00 | 330,915,290.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (105,646,742.32) | (131,179,470.40) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 134,478,896.00 | 47,552,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (24,901,385.09) | (27,991,972.13) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 415,581,698.33 | 401,004,356.33 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (85,213,244.73) | (96,250,113.34) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 138,439,191.80 | 152,464,191.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (26,598,001.76) | (41,022,045.46) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 15,015,800.00 | 15,015,800.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,933,974.47) | (3,313,038.47) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 13,748,000.04 | 13,660,000.08 |
| 39301 | Програм хангамж | 715,000.00 | 715,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (362,999.96) | (450,999.92) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,396,000.00 | 13,396,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,067,367,588.28** | **899,856,916.71** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **11,315,052.00** | **13,509,047.39** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 11,315,052.00 | 13,509,047.39 |
| **413** | **Өглөг** | 11,315,052.00 | 13,509,047.39 |
| **4136** | **Бусад өглөг** | 11,315,052.00 | 13,509,047.39 |
| 41366 | Дансны өглөг /ТӨҮГ/ | 11,315,052.00 | 13,509,047.39 |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,056,052,536.28** | **886,347,869.32** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,056,052,536.28 | 886,347,869.32 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 226,654,626.00 | 226,654,626.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 226,654,626.00 | 226,654,626.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 593,998,879.13 | 424,863,252.13 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 593,998,879.13 | 594,567,919.09 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (169,704,666.96) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 235,399,031.15 | 234,829,991.19 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,067,367,588.28** | **899,856,916.71** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,274,494,228.67** | **1,159,655,149.15** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **252,722,804.67** | **64,539,973.11** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 252,722,804.67 | 64,539,973.11 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 192,479,345.11 | 22,900,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 59,418,581.39 | 41,536,373.11 |
| 120010 | Төсөвт байгууллагын өөрийн орлого /туслах/ | 824,878.17 | 103,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,021,771,424.00** | **1,095,115,176.04** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,657,194.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,657,194.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 85,573,800.00 | 93,472,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 85,573,800.00 | 93,472,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 929,540,430.00 | 1,001,642,676.04 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 929,540,430.00 | 1,001,642,676.04 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,124,250,068.42** | **1,257,745,907.62** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,124,250,068.42** | **1,257,745,907.62** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,124,100,068.42 | 1,257,745,907.62 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 527,548,802.00 | 739,226,105.00 |
| 210101 | Үндсэн цалин | 293,534,135.00 | 469,591,873.00 |
| 210102 | Нэмэгдэл | 166,235,117.00 | 203,054,042.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,748,096.00 | 7,677,445.00 |
| 210104 | Урамшуулал | 58,688,454.00 | 58,902,745.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,343,000.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 66,942,145.00 | 92,353,639.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,146,945.00 | 63,929,115.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,948,800.00 | 7,689,783.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,959,200.00 | 6,054,899.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 989,600.00 | 1,334,774.78 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,897,600.00 | 13,345,065.93 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 91,090,452.00 | 92,666,495.39 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,478,374.00 | 6,793,415.39 |
| 210302 | Түлш, халаалт | 83,702,080.00 | 83,702,080.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,909,998.00 | 2,171,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 82,350,417.67 | 68,797,985.18 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,739,918.17 | 5,469,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,540,452.00 | 24,397,928.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,790,883.00 | 2,931,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,068,050.00 | 48,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 20,099,180.61 | 10,958,850.72 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 17,111,933.89 | 24,991,956.46 |
| **2105** | **Нормативт зардал** | 203,660,005.74 | 117,403,973.49 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 187,930,127.54 | 101,518,616.09 |
| 210502 | Хоол, хүнс | 15,709,378.20 | 15,190,357.40 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 20,500.00 | 695,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,006,570.00 | 21,017,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 14,275,000.00 | 925,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,731,570.00 | 20,092,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,470,000.00 | 1,276,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,470,000.00 | 1,276,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,327,310.00 | 3,538,988.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,088,650.00 | 1,158,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,170,000.00 | 1,152,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 79,920.00 | 80,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 49,400.00 | 61,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,940.00 | 33,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 244,400.00 | 40,188.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 661,000.00 | 1,014,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 122,704,366.01 | 121,465,720.90 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,522,707.00 | 5,778,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 99,181,659.01 | 115,687,720.90 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 150,000.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 150,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 150,000.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **150,244,160.25** | **(98,090,758.47)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 71,613,908.49 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө | | 71,613,908.49 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (71,613,908.49) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **150,244,160.25** | **(169,704,666.96)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,075,401,502.17** | **1,054,802,226.34** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **824,878.17** | **103,600.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 824,878.17 | 103,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,074,576,624.00** | **1,054,698,626.34** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,657,194.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,657,194.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 85,573,800.00 | 93,472,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 85,573,800.00 | 93,472,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 982,345,630.00 | 961,226,126.34 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 982,345,630.00 | 961,226,126.34 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **890,566,988.17** | **1,086,040,510.66** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **890,566,988.17** | **1,086,040,510.66** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **890,416,988.17** | **1,086,040,510.66** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 527,548,802.00 | 739,226,105.00 |
| 210101 | Үндсэн цалин | 293,534,135.00 | 469,591,873.00 |
| 210102 | Нэмэгдэл | 166,235,117.00 | 203,054,042.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,748,096.00 | 7,677,445.00 |
| 210104 | Урамшуулал | 58,688,454.00 | 58,902,745.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,343,000.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 66,942,145.00 | 92,353,639.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,146,945.00 | 63,929,115.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,948,800.00 | 7,689,783.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,959,200.00 | 6,054,899.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 989,600.00 | 1,334,774.78 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,897,600.00 | 13,345,065.93 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 79,775,400.00 | 90,472,500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,478,374.00 | 6,793,415.39 |
| 210302 | Түлш, халаалт | 72,387,028.00 | 81,508,084.61 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,909,998.00 | 2,171,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 50,696,478.17 | 32,311,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,367,178.17 | 2,070,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,096,500.00 | 19,566,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,153,900.00 | 2,931,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,507,900.00 | 2,744,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,571,000.00 | 5,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 93,916,453.00 | 83,682,578.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 67,815,453.00 | 62,215,680.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,559,500.00 | 15,466,898.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,541,500.00 | 6,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 28,100,750.00 | 29,151,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,360,750.00 | - |
| 210602 | Тавилга | 2,370,000.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 15,000,000.00 | 2,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,370,000.00 | 27,151,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,470,000.00 | 1,276,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,470,000.00 | 1,276,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,118,760.00 | 5,024,288.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,000,000.00 | 1,158,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,170,000.00 | 1,152,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 79,920.00 | 80,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 49,400.00 | 61,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,940.00 | 33,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 244,400.00 | 40,188.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 3,541,100.00 | 2,500,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29,848,200.00 | 12,542,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,848,200.00 | 12,542,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **150,000.00** | **-** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 150,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 150,000.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **184,834,514.00** | **(31,238,284.32)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **92,498,950.00** | **21,371,100.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **92,498,950.00** | **21,371,100.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 92,498,950.00 | 21,371,100.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 92,498,950.00 | 21,371,100.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(92,498,950.00)** | **(21,371,100.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 92,335,564.00 | (52,609,384.32) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 464,878.17 | 92,800,442.17 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 92,800,442.17 | 40,191,057.85 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 226,654,626.00 | 235,399,031.15 | 443,754,718.88 | 905,808,376.03 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **226,654,626.00** | **235,399,031.15** | **443,754,718.88** | 905,808,376.03 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 150,244,160.25 | 150,244,160.25 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **226,654,626.00** | **235,399,031.15** | **593,998,879.13** | 1,056,052,536.28 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 569,039.96 | 569,039.96 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **226,654,626.00** | **235,399,031.15** | **594,567,919.09** | 1,056,621,576.24 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (569,039.96) | - | (569,039.96) |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (169,704,666.96) | (169,704,666.96) |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **226,654,626.00** | **234,829,991.19** | **424,863,252.13** | 886,347,869.32 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,218,899,600.00 | 1,107,411,610.66 | 111,487,989.34 | 90.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,218,899,600.00 | 1,107,411,610.66 | 111,487,989.34 | 90.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,218,899,600.00 | 1,107,411,610.66 | 111,487,989.34 | 90.9 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 822,427,500.00 | 739,226,105.00 | 83,201,395.00 | 89.9 |
| 210101 | Үндсэн цалин | 502,538,600.00 | 469,591,873.00 | 32,946,727.00 | 93.4 |
| 210102 | Нэмэгдэл | 247,618,100.00 | 203,054,042.00 | 44,564,058.00 | 82.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,300,000.00 | 7,677,445.00 | (1,377,445.00) | 121.9 |
| 210104 | Урамшуулал | 65,970,800.00 | 58,902,745.00 | 7,068,055.00 | 89.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 107,327,300.00 | 92,353,639.66 | 14,973,660.34 | 86.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 72,982,500.00 | 63,929,115.86 | 9,053,384.14 | 87.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,586,500.00 | 7,689,783.82 | 896,716.18 | 89.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,869,400.00 | 6,054,899.27 | 814,500.73 | 88.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,717,100.00 | 1,334,774.78 | 382,325.22 | 77.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,171,800.00 | 13,345,065.93 | 3,826,734.07 | 77.7 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 90,472,500.00 | 90,472,500.00 | - | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,262,900.00 | 6,793,415.39 | (530,515.39) | 108.5 |
| 210302 | Түлш, халаалт | 81,089,600.00 | 81,508,084.61 | (418,484.61) | 100.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,120,000.00 | 2,171,000.00 | 949,000.00 | 69.6 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 32,567,900.00 | 32,311,900.00 | 256,000.00 | 99.2 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,070,000.00 | 2,070,000.00 | - | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,566,300.00 | 19,566,300.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,931,600.00 | 2,931,600.00 | - | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,000,000.00 | 2,744,000.00 | 256,000.00 | 91.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 84,128,100.00 | 83,682,578.00 | 445,522.00 | 99.5 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 62,215,700.00 | 62,215,680.00 | 20.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 15,912,400.00 | 15,466,898.00 | 445,502.00 | 97.2 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,000,000.00 | 6,000,000.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 50,522,600.00 | 50,522,600.00 | - | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,371,100.00 | 14,371,100.00 | - | 100.0 |
| 210602 | Тавилга | 7,000,000.00 | 7,000,000.00 | - | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 27,151,500.00 | 27,151,500.00 | - | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,500,300.00 | 1,276,000.00 | 224,300.00 | 85.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,500,300.00 | 1,276,000.00 | 224,300.00 | 85.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,422,500.00 | 5,024,288.00 | 398,212.00 | 92.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,350,000.00 | 1,158,000.00 | 192,000.00 | 85.8 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,152,000.00 | 1,152,000.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 80,000.00 | 80,000.00 | - | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 61,100.00 | 61,100.00 | - | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 35,000.00 | 33,000.00 | 2,000.00 | 94.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 244,400.00 | 40,188.00 | 204,212.00 | 16.4 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,500,000.00 | 2,500,000.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,530,900.00 | 12,542,000.00 | 11,988,900.00 | 51.1 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,530,900.00 | 12,542,000.00 | 11,988,900.00 | 51.1 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,218,899,600.00 | 1,054,802,226.34 | 164,097,373.66 | 86.5 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 93,472,500.00 | 93,472,500.00 | - | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 93,472,500.00 | 93,472,500.00 | - | 100.0 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,022,113,100.00 | 961,226,126.34 | 60,886,973.66 | 94.0 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,022,113,100.00 | 961,226,126.34 | 60,886,973.66 | 94.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 103,314,000.00 | 103,600.00 | 103,210,400.00 | 0.1 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,513,600.00 | 103,600.00 | 10,410,000.00 | 1.0 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 92,800,400.00 | - | 92,800,400.00 | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 92,800,442.17 | (92,800,442.17) | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 40,191,057.85 | (40,191,057.85) | - |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 32.00 | 32.00 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 26.00 | 26.00 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 | - | 100.0 |

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15,919.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 15,919.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 15,919.1 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 17,988.0 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 01 дугаар сарын 02-ны Б/01 тушаалаар Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолд заасан цалингийн хэмжээг нэмэгдүүлж 2023 оны эхний хагас жилд 15,919.1 мянган төгрөгийн цалинг албан хаагчдад илүү олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14-т “*Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно*”, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т “*Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүлжээний доод жишгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно*”, Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 8-д “*Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй*”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 “*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*” гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цалингийн хэмжээг нэмэгдүүлж илүү цалин олгосон | 1 | 15,919.1 | 1 | 15,919.1 | | | | |
| **Дүн** | **1** | **15,919.1** | **1** | **15,919.1** | | | | |

### Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 26 өдөр № 50/А2270439/ХӨА-2024/46/НА-СТА-ТШЗ Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 01 дугаар сарын 02-ны тушаалаар Засгийн газрын 2022 оны "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" 107 дугаар тогтоолоор тогтоосон цалингийн хэмжээг нэмэгдүүлж 2023 оны эхний хагас жилд 15,919,130.44 /арван таван сая есөн зуун арван есөн мянга нэг зуун гучин төгрөг дөчин дөрвөн мөнгө/ төгрөгийн цалинг нэр бүхий /хавсралтаар үзүүлэв/ албан хаагчдад илүү олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14-т "*Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно*", Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т "*Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүлжээний доод жишгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно*", Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 8-д "*Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй*", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 "*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*" гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Үндэслэлгүйгээр цалин нэмэгдүүлэн олгосон 15,919,130.44 / Арван таван сая есөн зуун арван есөн мянга нэг зуун гучин төгрөг дөчин дөрвөн мөнгө/ төгрөгийг төлбөрийн актын хавсралтад заасан албан хаагчдаар буцаан

6724020163

төлүүлж, Хөвсгөл аймгийн Төрийн сангийн 100170000955 /Хө.Бусад нэр заагдаагүй орлого/ тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн дарга Н.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Х.Дуламсүрэн нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч.ЭНХЧИМЭГ

[1] Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
2024 оны 02 дугаар сарын 26 –ны өдрийн
50/А2270439/ХӨА-2024/46/НА-СТА-ТШЗ
төлбөрийн актын хавсралт

## Илүү олгосон цалингийн жагсаалт

/төгрөгөөр/

| д/д | Албан тушаал | Овог | Нэр | Илүү олгосон цалин |
|---|---|---|---|---|
| 1 | 5-р багийн бага эмч | Батаа | Алтанхуяг | 937,953.14 |
| 2 | Ахлах сувилагч | Ганболд | Энхзул | 1,244,913.87 |
| 3 | Ариутгагч | Даваанян | Хишигсайхан | 959,766.00 |
| 4 | Туслах сувилагч | Далайбямба | Оюунтуяа | 530,734.00 |
| 5 | Үйлчлэгч | Доржготов | Туяа | 969,984.00 |
| 6 | Туслах сувилагч | Доржпагма | Энхцэцэг | 530,735.00 |
| 7 | Нярав | Жавзан | Батцэнгэл | 937,499.36 |
| 8 | Ф/эмчилгээний бага эмч | Жадамбаа | Цэрэнхүү | 959,766.00 |
| 9 | НЭМ-ийн ажилтан | Жийжээ | Сосорбарам | 754,101.86 |
| 10 | Багийн эмч | Зоригт | Даваажаргал | 998,826.00 |
| 11 | 3-р багийн бага эмч | Лать | Бат-эрдэнэ | 959,766.00 |
| 12 | Сувилагч | Мөнхбат | Дэлгэрмаа | 296,248.00 |
| 13 | Хүүхдийн их эмч | Мөнхбат | Энхцэцэг | 1,157,880.00 |
| 14 | Ээлжийн сувилагч | Нармандах | Анхтуяа | 888,744.00 |
| 15 | ЭЭС-ийн жор баригч | Товуутогтох | Ганчулуун | 959,766.00 |
| 16 | Тогооч | Түмэндэмбэрэл | Амаржаргал | 27,170.29 |
| 17 | Ээлжийн сувилагч | Түмэндэмбэрэл | Мөнхтуяа | 888,744.00 |
| 18 | Жолооч | Усника | Сэр-од | 796,104.00 |
| 19 | Эх баригч бага эмч | Цэрэнпил | Бат-эрдэнэ | 658,646.13 |
| 20 | Туслах сувилагч | Юндэндорж | Наранцэцэг | 461,782.79 |
| | **Нийт** | | | **15,919,130.44** |

oooOooo